

## Буриадын яруу найрагч Андрей Мухраевын шүлгийн монгол орчуулгын тухай

О.Чинбаяр /МОЭ/

М.Горькийн сургуульд нэгэн үе хамт суралцаж байсан Буриадын яруу найрагч, зохиолч, жүжгийн зохиолч, сэтгүүлч анд Андрей Мухраев зохиолч, орчуулагч, СГЗ Г.Аюурзана болон надад хандаж шинээр гаргах гэж буй шүлгийн түүвэртээ зарим нэгэн бүтээлүүдээсээ монгол хэл дээр орчуулж өгөхийг хүссэн юм. Орос хэл дээр зохиол бүтээлээ туурвидаг А.Мухраевын хувьд Монголын уншигчдад танил бус нэгэн ч зарим шүлгийг нь Г.Аюурзана бид хоёр эх хэлнээ буулгав.

Өнөөдрийн эрдэм шинжилгээний бага хуралд миний бие Буриадын яруу найрагч А.Мухраевын хэрхэн шүлгүүдийг орчуулснаа задлан авч үзэхээр болов. Мэдээж хэрэг өөрийнхөө орчуулсан шүлгийн арга барил, түүний онцлог, орчуулгын алдаа мэдгийн талаар өгүүлнэ гэдэг анхандаа санаанд багтахгүй байсан ч сэтгэл зориг шулуудан ийнхүү “задлан шинжилгээ” хийх нь яагаад байж болохгүй гэж хэмээн бодсоны сацуу зохиолч, орчуулагч нөхөр Г.Аюурзаны орчуулсан ганц нэг шүлгийн хөрвүүлгийн талаар өөрийн бодлоо илэрхийлэхээр шийдлээ. Эхлээд яруу найрагч А.Мухраевын зарим нэг шүлгийн орчуулгыг миний бие хэрхэн хийсэн гэдгээ тэс өөр судлаачийн нүдээр харж, үнэлэлт дүгнэлт өгөхийг оролджё.

*Эх шүлэг:*

### Песнь странника

Я не ищу в судьбе тревоги,  
К трудным вершинам не иду.  
Мои туманные дороги  
Всегда отчетливы в бреду...

*Хадмал орчуулга:*

### Бадарчны дуу

1. Би хувь заяанаасаа айдас хайгаагүй
2. Хүнд хэцүү оргил өөд яваагүй
3. Миний манант замууд
4. Үргэлжид дэмийрч байсан ч тодхон харагддаг

“Бадарчны дуу” хэмээх энэхүү шүлгийн эхний дөрвөн мөрийг би ийнхүү орчуулав.

**Шүлэглэсэн орчуулга:**

**Бадарчны дуу**

1. Хувь тавилангаас би айдсыг хайгаагүй
2. Хүрэхэд бэрх оргил өөд ч бас авираагүй.
3. Хүдэн татсан манант харгуй л
4. Хий дэмийрсэн ч тодхон үзэгднэм.

Энэхүү дөрвөн мөрийг уншихад яруу найргийн хувьд сүүл, толгой холбосон тодорхой хэмжээнд хайрцагласан байдлаар буулгахыг хичээв. Нөгөөтэйгүүр, эх шүлгийн санааг гажуудуулахгүйг ихэд анхаарч буулгав.

Яруу найргийн орчуулгын хувьд дээрх дөрвөн мөр эх хэл дээр маань хэрхэн яруу сонсголонтой буусныг хэлж мэдэхгүй ч ямартай ч миний бие аливаа зохиолыг орчуулахдаа эх санааг нь өөрийн болгон “өмчлөхийг” хэзээ ч санаархдаггүй бөгөөд аль болохоор Андрей Мухраевын чин сэтгэлийн хөөрлийг олон жил найзалж нөхөрлөж яваагийн хувьд монгол дээр шүлгээ бичсэн бол ийнхүү буух байсан болов уу хэмээн санаж хөрвүүлсэн нь энэ болой.

**Мөн уг шүлгийн сүүлчийн бадаг:**

“...И полюбил я жизнь эту,  
Как узник полюбил тюрьму.  
Я лишь для Бога вышел к свету,  
Но для людей я канул в тьму” гэж төгсдөг билээ.

**Хадмал орчуулга:**

1. Тиймээс би энэ амьдралд хайртай болсон
2. Яг л хоригдол шорондоо дурладаг шиг
3. Гагцхүү би Бурханы төлөө олны өмнө ил гарсан
4. Гэвч хүмүүсийн хувьд би харанхуйд уусч алга болсон

**Шүлэглэсэн орчуулга:**

1. Нарсанд суугаа хоригдол гяндандаа дасдаг шиг
2. Насан туршийн амьдралдаа би хайртай.
3. Бурханы нэр барьж олны өмнө гарсан ч
4. Бусдын хувьд би хэдийнэ үгүй болсон.

Уг дөрвөн мөртийн хэлэх гэсэн санааг орчуулагч миний бие хэрхэн үнэн зөв ойлгож, эх хэл дээрээ буулгасныг эрхэм мэргэд та бүхэн шүүн тунгаах биз ээ. Юутай ч миний хувьд дөрөв дэх мөрний “канул в тьму” гэсэн үгийг “харанхуйд унаж алга болсон” хэмээн шууд утгаар нь ойлгосон бол шүлгэндээ “Бусдын хувьд би хэдийнэ үгүй болсон” хэмээн утгыг нь монголчилж,

нэг ёсондоо өөрийгөө нас барсан, хэнд ч хэрэггүй болсон, хүн биш болсон гэсэн санаагаар хөрвүүлсэн болно. Тэгвэл Ц.Дамдинсүрэн гуайн толь бичигт “кануть” гэсэн үг нь эртний, хуучирсан үгсийн тоонд багтдаг агаад “шунгах, живэх, үгүй болох” гэсэн утгыг илэрхийлдэг ажээ. “Кануть в прошлое” гэвэл “улиран үгүй болох”, “как в воду кануть” гэвэл “сураг танаггүй болох” хэмээн тайлбарлан орчуулсан байна. Харин “кануть во тьму” гэдэг нь “харанхуйд уусах” гэсэн утга санааг илэрхийлж байна.

**Эх шүлэг:**

Не жизнь и смерть, а просто надо,

Чтоб ты простила и пришла...

Как эта красная помада

Сладит знакомые уста... гэсэн нэргүй нэгэн шүлгийн эхний дөрвөн мөртийг хэрхэн орчуулсныг авч үзье.

**Хадмал орчуулга:**

1. Амьдрал болон үхэл биш, харин заавал ч үгүй
2. Чи уучилж ирэх нь чухал байна
3. Яг л энэ улаан уруулын будаг шиг
4. Хэдийний танил уруулыг шилэмдэнэ.

**Шүлэглэсэн орчуулга:**

1. Улаахан өнгөтэй уруулын будаг
2. Уруул юуг нь зөөлөн шилэмдэх
3. Үхэл, амьдралын аль нь ч бус аа
4. Үнэнч наддаа эргээд ирвэл л боллоо...

“Сладит знакомые уста” гэсэн үгний “уста” гэдэг нь хуучирсан орос үг бөгөөд “ам, ярих” гэсэн утгатай үг бол дээрх өгүүлбэрт “танил уруул шилэмдэнэ” гэсэн шууд утгыг илэрхийлж байна.

Яруу найргийн орчуулгын хувьд миний бие эх зохиолоо сайтар мэдэрч байж гэмээнэ аль болохоор шүлгийн санааг тэр чигээр нь гажуудуулалгүйгээр буулгах нь зөв зүйтэй гэж үздэг. Харин өөрийн зүгээс ямар нэгэн гоёчлох юм уу толгой, сүүл холбох үүднээс илүү дутуу санаа нэмж хачирлах нь яруу найрагчийн хэлэх гэсэн санааг дэгсдүүлэх, аль эсвэл бүр өөр байдлаар ойлгуулах явдал гарахаас сэрэмжлэх нь зүйтэй гэж бодож явдаг. Шүлгийн хэмнэл, үгийн сонголт, толгой холбох асуудал нь яруу найргийн хувьд зайлшгүй байх ёстой зүйл боловч хамгийн гол нь тухайн орчуулж буй зохиолынхоо гүнд нь орж сайтар мэдрэх нь чухал билээ.

**Ашигласан номын жагсаалт:**

1. Андрей Мухраев “Шүлгийн түүвэр” 2013 он, Улаанбаатар хот
2. Ц.Дамдинсүрэн Орос-Монгол толь, 1980 он, Улаанбаатар
3. С.И.Ожегов Словарь Русского языка, 1977, Москва